



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/09

Улаан-Уул

Акталсан хөрөнгийг устгах  
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэсвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.6, Төсвийн тухай хуулийн 14.2.10, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 156 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төсөвт байгууллагуудын актлагдсан хөрөнгийг хүлээн авч, устгах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: С.Хонгорзул (Санхүүгийн албаны дарга)

Гишүүдэд: О.Энхболд (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Г.Баасанжаргал (Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Д.Сайханцэцэг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Б.Азжаргал (Хөдөө аж ахуй тасгийн мэргэжилтэн)

2. Акталсан хөрөнгө бүрийг нүд үзэн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн талаарх санал дүгнэлт, тайланг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг (С.Хонгорзул)-д үүрэг болгосугай.



ДАРГА *Энх* Т.ЭРДЭНЭБАТ

642101171